

**“Улаанбаатар хивс” ХК-ийн 2023 оны ХЭХ-ын ээлжит хурлын
тэмдэглэл**

2023-03-31

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023-03-31-ний 11:00 цагт компанийн хурлын танхимд болов.

Ё.Энхтөр /Хурлын дарга/: “Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна. Ирцийн талаар тооллогын комиссоос мэдээлнэ.

Г.Бат-Эрдэнэ /Тооллогын комиссын гишүүн/: Тооллогын комиссын тогтоол №1-ийг танилцуулав:

Хуралд 2023-03-09-ний бүртгэлийн өдрөөр бүртгэгдсэн 241141 ширхэг хувьцааг төлөөлсөн 16 хувьцаа эзэмшигч оролцож байна. Энэ нь нийт хувьцаа эзэмшигчдийн 59,57 % буюу ирц бүрдсэн тул хурлыг хүчин төгөлдөр гэж үзэж байна.

Ё.Энхтөр: Хурлын дэгийг танилцуулъя. Хэлэлцэх ас уудал:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны үр дүн, 2023 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай
2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагын хийсэн дүгнэлт
3. “Улаанбаатар хивс” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв батлуулах

Эхлээд, асуудлуудаа хэлэлцээд дараа нь санал, шүүмжлэл хүн бүр 5 минут байна. Хэлэлцэх асуудлаар санал хураалт явуулж, дүнг танилцуулна.

Ц.Зоригт: Та бүхэнд тараагдсан материал дээр дэлгэрэнгүй байгаа. Компани эрхэм зорилгын хүрээнд ХЭХ-аас дэвшүүлсэн зорилтуудаа ханган биелүүлэх талаар ажиллаж ирлээ. 2021 оны үйл ажиллагааны үр дүнгээр нэгж хувьцаанд 1200 төгрөг хуваарилж байсан бол 2022 оны үр дүнгээр 1570 төгрөг хуваарилахаар ТУЗ-өөр шийдвэр гаргасан.

2022 онд ТУЗ 3 удаа хуралдаж, асуудлуудыг шийдэж ирлээ. СЗХ-ны тогоолын дагуу “Компанийн засаглалын кодекс”-ын журмуудыг шинэчилж Website-д байршуулсан.

ТУЗ-ийн даргын хувьд, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, техник, технологийн шинэчлэл хийх, борлуулалт маркетингийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага, хамт олонтой хамтран, асуудлуудыг газар дээр нь шийдэж, шүүрхай ажиллаж ирлээ.

2022 оны үйл ажиллагааны үр дүн:

- 50338 м2 хивс үйлдвэрлэж, 49616 м2 хивс борлуулсан нь үнийн дүнгээр 5,404,974 сая төгрөгт хүрч, урьд оноос 725, 506 сая төгрөгөөр буюу 16%-аар өсөв.
- 838,015 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оныхоос 105,333 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дээрх үр дүнд хүрэхэд компанийн нэгж, албад дараахь ажлуудыг гүйцэтгэлээ.

1. Үйлдвэрлэлийн алба

- 2022 онд 245,7 тн ноос бэлтгэлээ.
- Ноос ялгалтын гарц 74,0%, угаалтын гарц 56,6% байлаа.
- Ээрэх цехэд:
 - o 12/3 номерын утас 21812 кг
 - o 15/3 номерын утас 58993 кг, нийт 80805 кг утас ээрч, ээрмэлийн гарц 72,0% байв.
 - o Хялгас ялгах цехэд 3140 кг ноос ялгаж, гарц нь 20 % байлаа.
- Будах цехэд:
 - o 80689 кг утас будаж төлөвлөгөө 93,14%-тай биелэв.
 - o Будах III аппаратыг автоматжуулах, будалтын горимыг хянах самбарт тохируулах, уур усыг автоматаар хаадаг болгох зэрэг ажлууд хийснээр эрчим хүчний хэмнэлт гарахаас гадна будалтын чанарт сайнаар нөлөөлөх болсон.
- Нэхэх цехэд нэхсэн хивсний нэр төрлийг үзүүлбэл:

o Алтанбулаг	34732,51 м2
o Саян	13923,75 м2
o Алтан-Өргөө	497,00 м2
o Улаанбаатар	652,00 м2
o Богд	1107,55 м2
o Отгонтэнгэр	96,00 м2 буюу нийт 51009,58 м2 хивс нэхэв.
- Нөхөн засах гүйцэтгэх цехэд 50338 м2 хивс гүйцэтгэн боловсруулав.
- Оёдлын тасагт, гудас, сандлын хивс, тааран уут, хивсэн углааш, ажлын хувцас зэргийг үйлдвэрлэн борлуулалтанд тушаалаа.

2. Маркетингийн алба

- Тайлант онд 49616 м2 хивс борлуулсан нь өмнөх оныхоос, үнийн дүнгээр 16,0% өссөн.
- Нэрийн барааны дэлгүүрүүдээр борлуулалт хийснээс гадна 94 захиалагчийн 3137 м2 хивсийг 390 066 600 төгрөгөөр гүйцэтгэв.
- Экспортод 1086 м2 хивс гаргаж, 115,3 сая төгрөгийн борлуулалт хийсэн.

- Монголын зах зээлд 2022 онд "Натурал текстайл" групп 341 710 м2 хивс, манай компани 50300 м2 үйлдвэрлэсэн нь ойролцоогоор 12,0%-ийг эзэлж байна.

3. Сургалт-хүний нөөцийн алба

- Оны эхэнд 114 ажилтантай байсан бол, ажилд шинээр 20 хүн орж, 14 хүн үлдэж, бусад 13 хүн халагдсанаар оны эцэст 115 ажилтантай болоод байна.
- Ажиллагсдын дундаж нас 46 ба компанид ажилласан дундаж жил 14 байна.
- Нийт ажиллагсдын 35% нь тэтгэврийн насных байна.
- Одоогоор 16 ажлын байранд сул орон тоо байгаа бөгөөд яаралтай сургах шаардлагатай мэргэжил байна.

4. Санхүү-эдийн засгийн алба

- Баянхонгорт авсан 149400 кг, Улаанбаатарт авсан 96350 кг ноосны 392,1 сая төгрөгийг барагдуулж, ноосны урамшууллын тооцоог 896 малчин тус бүрээр Е-баримтаар тулган, ННХ болон татварын байгууллагад мэдээлсэн.
- Турк улсаас 4,0 сая төгрөгийн гэр ахуйн байраа онлайнаар захиалж, авчран борлуулж, 4,5 сая төгрөгийн ашиг олсон. Одоогоор 6,1 сая төгрөгийн бараа нэмж захиалаад байна.
- "Транскапитал" ББСБ-тай гэрээ байгуулснаар, 22,0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.
- Хивсний борлуулалтын үнэд өөрчлөлт оруулах тооцоог хийж, 2022-01-13-наас хивсний үнийг 10-20 % нэмэгдүүлсэн.
- Үндсэн хөрөнгөнд 627,6 сая төгрөгийн орлого авч бүртгэлд тусгасан.

5. Бусад ажлууд:

- Компанийн барилгын дээврийн 11090 м2 талбайд мембран наалт нааж 562,3 сая төгрөг зарцуулаа.
- Ноосны складын дээвэр 1380 м2 талбайг хар цааслав.
- 120 уртааш метр ус зайлуулах шугам хоолой шинэчлэв.

2023 оны үйл ажиллагааны үндсэн зорилт, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийн төлөвлөгөөг танилцуулъя.:

- Үйлдвэрлэл	52000 м2
- Борлуулалт	6 200 000,0 мян. төгрөг
- Хөрөнгө оруулалт	600,0 сая төгрөг
- Цэвэр ашиг	900,0 сая төгрөг
- Үйлдвэрлэлийн нэгж өртөг	95000 төгрөг-өөр тус тус төлөвлөж байна.

Ё.Энхтөр: Баярлалаа. 2-р асуудалдаа оръё: Компанийн 2022 оны санхүүгийн тайланд аудитын компаниас өгсөн дүгнэлтийг аудитын хорооны дарга танилцуулна:

Г.Батхүрэл: Компанийн санхүүгийн тайланд "АяТакс аудит" ХХК-аас аудит хийсэн байна. Шалгалт хараахан дуусаагүй байгаа учир урьдчилсан дүгнэлт ирүүлснийг овч таилцуулъя. Компанийн 2022 оны жилийн эцсийн тайлангаар:

- Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө: 1.916.939.018 төгрөг
- Нийт хөрөнгө: 15.062.977.862 төгрөг
- Нийт өр төлбөрийн дүн: 2.226.988.633 төгрөг
- Борлуулалтын орлого: 5.404.974.120 төгрөг
- Нэгж хувьцаанд ногдох ашиг: 2 170 төгрөг
- 2022-12-31-ний үлдэгдэл: 12.876.472.129,72 төгрөг түс байна.

"Улаанбаатар хивс" ХК-ийн 2022 оны 12-р сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайлангуудад санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх үр дүн, мөнгөн гүйлгээг СТОУС-ын дагуу үнэн зөв хийсэн гэсэн дүнэлт ирүүлжээ.

Ё.Энхтөр: Баярлалаа. Хэлэлцэх 3-р асуудалд орёе. ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга танилцуулна.

Н.Батцэцэг: ТУЗ-ийн үйл ажиллагааны 2023 оны зардлыг 2-р сарын 16-ны ТУЗ-ийн хурлаар оруулж батлуулсан ба ХЭХ-д оруулж байна. Зардлын задаргааг танилцуулъя:

- Цалин: ТУЗ-ийн дарга сарын 650 Мтөг, 8 гишүүн түс бүр 450 Мтөг, нарийн бичгийн дарга 550 Мтөг, хуралд оролцсон нэмэгдэл: гишүүн бүрт сард 100 Мтөгрөг олгохоор төлөвлөсөн. Түүнчлэн,

- Бичиг хэрэгслийн зардалд 500 Мтөг,
- Хэвлэл, телефоны зардалд 2000 Мтөгрөг,
- Сургалт, аттестатчилал болон бусад зардалд 1500 Мтөгрөг, нийт 72,4 сая төгрөгийг төлөвлөж байна.

Ё.Энхтөр: Баярлалаа. Одоо санал, шүүмжлэл, асуулт, хариултандаа орёе.

Г.Гансүх: Би олон компаниудын ХЭХ-д оролцдог. Зарим нь их муу байдаг. Харин "Улаанбаатар хивс" ХК нь жил бүр ирэхэд ашиг, орлого нь нэмэгдсэн, сайн байдаг. Би баярласнаа хэлэх гэсэн юм.

Ц.Содбаатар: Компанийн хувьцаа их үнэтэй, Ойролцоогоор, 30000 төгрөг байдаг. "АПУ", "Говь" зэрэг компаниуд шиг хувьцаагаа хувааж, олон хүмүүст хүртээмжтэй болгох саналтай байна.

Ё.Энхтөр: Энэ талаар судалж үзэж болно. Манай хувьцаа төвлөрсөн байдаг болохоор.

С.Мягмарсүрэн: Үндсэн үйл ажиллагааны ашиг бага, түрээсээр нилээд ашиг олдог юм байна. "Номин" ХХК-д талбайгаа хямд түрээсэлдэг юм байна. Түрээсээ нэмж болохгүй юу?

Б.Баясгалан: Хамгийн гол нь удаан хугацаанд, найдвартай түрээслэгч гэдэг утгаар нь түрээсээ тогтоосон. Тэгээд ч түрээсийн төлбөр, 50% нь валютын ханшаас хамаарна гэсэн гэрээтэй. Мэдээж, түрээсээ өндрөөр санал болгосон л доо. Тэгээд харилцан тохиролцож гэрээ байгуулсан. Дараагийн удаа дахин ярилцаж болно.

М.Шигшээ: Компанийн ажил сайн байна. Нэг санал байдгаа хэлье. Хивсээ гадаадад гаргах талаар: Хилийн боомтуудаар цаанаасаа орж ирдэг хүмүүст хивсээ борлуулах агенттай ажиллуулбал яах вэ?

Хөвсгөл, Завханаар орж ирдэг Тува хүмүүс, Хэнтийн хилээр Буриадууд, Баян-Өлгийгөөр казакууд их орж ирдэг. Мөн Гашуун сүхайтаар орж ирдэг Хятад иргэд гэх мэт. Тэнд нь борлуулалтын агент ажиллуулбал болох бол үү гэж боддог.

Ц.Зоригт: саналыг хүлээж авлаа. Судална аа.

С.Пүрэвжав: Ажиллах хүчин дутагдалтай гэж байна. Ажилчдаа яаж бэлддэг вэ? Дундаж цалин ямар байдаг вэ?

Б.Баясгалан: Энэ жил манай цалин нилээд өссөн. Дундаж цалин 1,5-2,0 сая төгрөг болсон. 3,0 сая гаруй цалин авдаг нэхэгч ч байдаг.

Ц.Зоригт: Мэргэжилтэй ажилчин бэлтгэх систем байдаггүй.

Ё.Энхтөр: Санал тавьж, асууж оролцсон хувь нийлүүлэгчдэд баярлалаа. Бид гарсан саналуудыг ярина. ТУЗ-ийн хурлаар ч оруулах шаардлагатай байж болно. Одоо хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс хэлэлцсэн асуудлуудаар өгсөн санал хураалтын үр дүнг тооллогын комисс танилцуулна.

Г.Бат-Эрдэнэ: Тооллогын комиссын тогтоол №2-ыг үншиж сонсгов. Оролцогсод 3 асуудалд 100% зөвшөөрсөн санал өгчээ.

Ё.Энхтөр: Одоо хэлэлцсэн асуудлаар хурлын тогтоолын төслийг танилцуулъя. 2 тогтоолын төсөл танилцуулав.

Хувьцаа эзэмшигчид санал нэгтэй батлав.

Ё.Энхтөр: Баярлалаа. Хурал үүгээр өндөрлөж байна. Гарсан саналыг бид судална.

Хуралд оролцогчид: Баярлалаа. Хойтон улам их ашигтай ажиллаараай.

Хурал 14:30-д өндөрлөв.

Хурлын тэргүүлэгчдийн дарга



Хурлын тэмдэглэл хөтөлсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Н.Батцэцэг